

**МОНГОЛ УЛС ДАХЬ ИСЛАМ: ТҮҮХ,  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ**

М.Хурметхан\*

**Товч утга**

**Т**ус өгүүлэлд Монгол улс дахь исламын шашны түүх, өнөөгийн байдал, хэтийн төлвийн талаар тусган харуулжээ.

**Түлхүүр үг:** Монгол Улс, Ислам, Төв Ази, Казах

Монгол Улс бол Исламын шашинт хүмүүс аж төрдөг улсуудын нэг юм. Тус улсад исламын шашин XIII зуунд нэвтэрч эхэлсэн бөгөөд Хархорум хотод 2 мечеть ажиллаж байжээ. Хэрмээр бэхлэгдсэн 1,6 км<sup>2</sup> талбай бүхий тус хотод 10-15,000 орчим хүн оршин сууж байсан бөгөөд нилээд олон тооны мусульманчууд байсан бололтой. Мөн тус хотод мечеть барьсан тухай перс хэлээр бичсэн гэрэлт хөшөө, хадгалагдаж үлдсэн бөгөөд археологийн судалгааны явцад мусульманы оршуулгын газар илэрсэн байна. 1340-1341 онд бичигдсэн гэрэлт хөшөө нь боржин чулууг сайн тэгшилж, нүүрэн талд перс хэлээр 37-38 мөрийг 2-5 см-ийн өргөнтэйгээр сийлжээ. Харин сүүлд XVII зуунд Өндөр гэгээн Занабарын зохиосон соёмбо үсэг, төвд, санскрит, уйгуржин монгол бичгээр маанийн 6 үсэг сийлсэн байна.

Перс бичгийн утга нь исламын шашны зүтгэлтнүүд Монгол хаадын сайн сайхны төлөө ...Өдрөөс өдөрт, сараас сард бүрээ дуугарах хүртэл дурсагдах, бас эргэн мандах өдрийг хүртэл хүн бүхэнд мэдрүүлж, үүрд үргэлжлэн, мөнхөд орших болтугай хэмээн тэнгэрт залбирч, 1340 онд Хархорум хотын эрх мэдэл бүхий жанжнуудын зөвшөөрлийг авч, тэнд сууж байгаа мусульманчуудын хамтаар метечь барих болсон тухай түүхийг бичээд хөшөөний төгсгөлд хандив өргөсөн хүний нэр, хандивын дүнг тэмдэглэсэн байна.<sup>1</sup>

\*М. Хурметхан - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)

Монголчуудын дунд Ислам дэлгэрэх нь Чингис хааны Дундад Азид хийсэн аян дайны дараа улам эрчимтэй болжээ. Эзэлсэн орнуудыг захиран үлдсэн Чингис хааны хөвгүүд, ач нар хийгээд цэргийн жанжингуудын үр сад нь 2 голдуу 3 дахь үеэс эхлэн исламын шашинд орж, тэдгээр ард түмнүүдэд шингэжээ. Тэдгээр хүмүүсээс исламын ертөнцөд алдартай хүмүүс олноор төрөн гарсан байна.<sup>2</sup> Казахстаны зохиолч Гизат Табылдиний “XII-XXI зуундахь Чингис хааны удам угсааны угийн бичиг” хэмээх номонд

Чингис хааны үр сад 10,000 хүний намраас харахад мусульманчууд цөөнгүй нь харагдаж байна. Чингис хааны Y хромосомын генетикийн код Азийн 16 ард түмний дунд тархсан байдаг бөгөөд дэлхий дахинд энэхүү генетикийн ул мөр 0,5 эрэгтэй хүмүүст илэрчээ. Харин статистикийн мэдээгээр дэлхийд Чингис хааны 16 сая хүн үр удам аж төрж байгаа билээ. Эдгээр түүхэн баримтаас үзэхэд Ислам нь Монголд дундад зууны үеэс эхлэн дэлгэрэн танил болсон байна.

Шинэ үед Монгол оронд ислам шашинтан хүмүүс үзэгдэх нь 300-аад жилийн өмнөөс Дорнод Туркестанаас хотон угсаатан Увсад ирж суурьшсан болон Алтайн ууланд Казахууд дахин нутаглаж эхэлсэн XVIII зуунтай холбоотой юм. Одоогийн Монгол улсын баруун талаар нутагласан казахууд 1880-1911 онд Ар Монгол тусгаар тогтноход түүний бүрэлдэхүүнд багтжээ. Өнөөгийн Баян-Өлгий аймгийн нутагт 1905 он гэхэд 1370 казах өрх айл нутаглаж байсан бол 1923 онд барагцаалбал 11220 казах байжээ. Харин 1934 онд 3834 өрх 18699 казах байсан ба тэдгээрээс 1276 нь молла хэмээн тэмдэглэсэн байна.

Монголын шашны амьдралын өөрсдийн өвөрмөц онцлог нь исламын шашинд бас тусгалаа олсон байдаг. Монголын мусульманчууд болох казах, уйгур, өзбек, хотон нарын шашны уламжлалын тухай янз бүрийн цаг үед ирсэн жуулчдын тэмдэглэл, судалгаа байдаг. Эдгээрт исламын дэлгэрсэн түүх, нийгэм дэх байр суурь, орон нутгийн эртний итгэл үнэмшилтэй харьцаа, өнөөгийн цагт шашинд итгэх байдлын илрэл, дэлгэрэлт, нөлөө гэх мэт туссан байдаг. Монгол дахь казахуудын хувьд исламын өмнөх үеийн сүсэг бишрэлийн илрэлүүд байдаг бол хотончуудад буддын шашны элементүүд багтдаг байна. Гэхдээ Баруун Монголд казахууд нутаглах тэр үедээ исламын шашин тэдний хувьд бүрэн батжиж бэхжээгүй байжээ. Түүнийг цаашид дэлгэрүүлэхэд Хаант Оросоос илгээсэн шашны төлөөлөгчид болон Казан хотод хэвлэгдсэн исламын ном зохиол чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн Алтайн уулын казахын

дундаас төрөн гарсан соён гэгээрүүлэгч, их яруу найрагч Акыт хажы Улумижулы Карамсаков Алтайский (1860-1940) ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Тэрвээр 1890 онд анхны номоо Казан хотод хэвлүүлэхдээ исламын шашныг сурталчилахад зориулсан байдаг.

Өнөөгийн Монгол Улсын баруун хэсгийн казахууд нутагласан цагаас эхлэн 1921 оны ардын хувьсгал хүртэл шашны эрх чөлөө хэвийн байж, мусульман шашны сургалт явагдаж, түүнийг даган биелүүлэхийн хамтаар хүүхдүүдээ медресэд сурган, хажид очиж, идэвхтэй шашны амьдралтай мусульманчууд байлаа. Ер нь Дундад Азийн бусад ард түмнүүдтэй харьцуулахад казахууд шашны фанатизмд гүнзгий автаагүй юм. Учир нь Алтайн уулын казахуудад шашин нилээд хожуу дэлгэрсэн, мусульманы шашны төвүүдээс алс хол оршдог нь нөлөөлсөн байна. Тэрчлэн казахууд исламын шашныг дутуу дулимаг эзэмшсэн гэдэг ойлголт бас үндэслэлгүй байдаг ажээ.

1921 оны Монгол ардын хувьсгал исламын суурийг ганхуулсан байна. 1921-1938 онуудад Монголын засгийн газраас исламын эсрэг эрс хатуу бодлого явуулжээ. Тэр үед 10-аад мечеть болон ариун судрыг шатааж, шариатын шүүхийг хориглов. 1937-1938 он гэхэд 21000 казах хүнээс 3270 голдуу баян, шашны зүтгэлтэн хүнийг цаазаар авчээ. 1940-1960 онд Өлгий хотод ганц мечеть ажиллаж байгаад хаагдсан байна. 1978 онд исламын шашин, казахын ёс заншлыг устгах шинэ аян эхэлж, байдлыг улам хүнд болгожээ. Өмнө нь мечеть хаагдаж, мусульман хүмүүс хэлмэгдэн хавчигдсан нь исламын боловсролын тогтолцоог сүйрүүлсэн байна. Казахуудын ахуй өөрчлөгдөж, исламын шашины зан үйл хязгаарлагдсан нь атеизм дэлгэрэхэд нөлөөлсөн байна. Үүнийг үл харгалзан гэр ахуйн хүрээнд шашны итгэл үнэмшил, зан заншил казахын нийгэмд оршиж байсан юм. Гэр бүл, ах дүүгийн харилцаан дахь исламын болон исламын өмнөх ёс заншлыг устгахад чиглэсэн энэхүү бодлогын хэрэгжилтийн явцад нас барагсдыг оршуулах ёс, гашуудал, гэр бүл болох, казах хэлээр ярих, казах хувцас өмсөхийг хориглож, харам идэхийг хүчээр тулгаж байлаа ч хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан ажээ.

Социализмын нийгмийн үед исламын шашинд итгэгчид хоёр бүлэгт хуваагдсан байлаа. Залуудаа ислам шашны боловсрол эзэмшсэн, өөрсдийгөө жинхэнэ мусульман хэмээн тооцдог, мусульманы зан зүйлийг баримталдаг ахмад үеийн хүмүүс, Шашны хэм хэмжээг хатуу баримталдаггүй, шашны боловсрол хангалтгүй хүмүүсээс бүрдсэн ахмад дунд насны болон зарим залуучууд ордог

байлаа. Мөн социалист нийгмийн үед Монголын мусульманчуудын дотор шашны үйл ажиллагааг шашны боловсролыг янз бүрийн түвшинд эзэмшсэн 160-аад молла ил, далд хэлбэрээр явуулсаар 1990 онд ардчилсан үйл явцтай золгосон байна.

Өнөөгийн үед Монгол Улс бол 2,8 сая хүн амтай. Тус оронд шашин шүтэх, эс шүтэх нь эрх чөлөөтэй, үндсэн хуулиар баталгаажсан байдаг бөгөөд буддын болон исламын шашныг уламжлалт шашнаа хэмээн тодохойлсон ажээ. 1991 он гэхэд Монголд шашны үйл ажиллагаа явуулдаг Гандантэгчилэн гэсэн буддын ганцхан сүм байлаа. Тэгвэл түүнээс хойш ойрын 20 илүү жилд ардчиллын ачаар болон үзэл суртлын хоосон орон зайг эзлэх замаар шашны үйл ажиллагаа явагдсаар Монгол Улс нь шашны амьдралын шинэ төрхтэй болов. Өнөөгийн байдлаар бүрэн бус мэдээгээр буддын 240, христын (ортодокс) 161, исламын 44, вахайн 5, шаманизмын 5, бусад 3 зэрэг нийт 457 сүм, мечеть үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын 2010 оны хүн амын тооллогын дүнгээс үзэхэд 15 ба түүнээс дээш хүн амын шашин шүтлэг нь дараах байдалтай байлаа. Үүнд, 15 ба түүнээс дээш хүн ам 1905969 (100%) байсан ба тэдгээрээс шашин шүтдэггүй нь 735283 (38,6%), шашин шүтдэг нь 1170283 (61,4%) байжээ. Шашин шүтдэг хүмүүсээс буддын шашинтан 10009357 (53%), христ 41117 (2,1%), ислам 57702 (3%)-ийг тус тус эзэлж байв.<sup>3</sup>

Тус улсад исламын шашинтны дийлэнх хэсгийг казах, уйгур, үзбек, хотон эзэлдэг бол цөөн тооны монгол хүмүүс ч исламыг баримталдаг. 2012 оны хүн амын тооллогоор казах 101526 (3,86%), хотон 11304 (0,43%), уйгур 282 (0,01%) байсан бөгөөд исламын шашинд хамаарагддаг хүмүүсийн 51% нь шүтлэгтэй болох нь тэмдэглэгджээ. Гэхдээ дээрх мэдээнээс өөр тоо мэдээ бас байдаг бөгөөд казах хүн ам 120000 илүү, хотон нар 30000 гэсэн байдаг. Баян-Өлгий аймгийн хүн амыг 90%-ийг, Ховд аймгийн хүн амын 11,5%-ийг казахууд эзлэхийн хамтаар Улаанбаатар, Налайх, Эрдэнэт, Дархан хот, Төв, Сэлэнгэ аймагт олноор аж төрдөг. 1956 онд тус улсад 37000 (4,3%) казах байсан бол 1989 онд 121000 (6,1%) болжээ. Казахстан руу хүмүүс олноор нүүсний улмаас тоо нь багасаж, 2000 онд 103000 (4,3%) байв. Харин 2007 онд 140000 (5,4%) хүрч байлаа. 1991-2009 оны хооронд Монголоос Казахстанд 22259 өрхийн 109771 хүн шилжин суурьшжээ.<sup>4</sup>

Монгол Улсад исламын шашин 1990-ээд оноос сэргэн дэлгэрч эхэлсэн билээ. 1990 оны 10-р сард Монголын Мусульманы Нийгэмлэг ('The Mongolian Islamic Society') байгуулагдан үйл



ажиллагаа явуулан, улмаар шинэ нөхцөлд зохицуулан, 2007 оноос Монголын Исламын Байгуулагуудын Холбоог (ММУО) байгуулсан билээ. Холбоо нь өөрийн зохион байгуулалт, дүрэмтэй бөгөөд түүнд исламын 44 мечеть, 10 медресе хамаарагдана. Уг холбоо нь исламын орнуудын шашны байгууллагуудтай нягт хамтран ажилладаг бөгөөд тэдгээрээс санхүүгийн дэмжлэг авдаг. 70 жил тасарсны дараа 1991 оны монголын мусульманчууд явж эхэлсэн бөгөөд одоогоор 200 хүнээ (4 хотон, нэг монгол бусад нь казах) илгээжээ. Замын хол, эдийн засгийн бэрхшээл, квот зэргээс шалтгаалан хүссэн хүн болгон явж чадахгүй байгаа. Шашны боловсон хүчнийг эх орондоо болон исламын орнуудад бэлтгэдэг ба одоогоор исламын орнуудад 2000 хүн бэлтгэсэн ба үргэлжлүүлэн сургаж байна.

Гэхдээ Монголд исламын агуулга, хэлбэр, үзэгдэл олон янз байдаг. Юуны өмнө ардын исламын шашин ба албан ёсны исламын шашин гэж хоёр хувааж болно. Ардын исламын шашин нь казахын нүүдлийн соёл иргэншилд зохицсон, ардын уламжлал, зан заншилд тулгуурласан ба түүнийг элементийг агуулсан байдаг. Исламын шашин шүтдэг хүмүүст жинхэнэ сүсэгтэн, тогтворгүйчүүд, үл итгэгчид болон заримдаа атейст нар ч багтаж байдаг. Бүрэн бус судалгаанаас үзэхэд Монголын мусульманчуудын 24% нь жинхэнэ сүсэгтэн, 43% тогтворгүйчүүд, 12%-ийг үл итгэгчид, атейстууд эзэлдэг бололтой.

Монголын мусульманчуудын хувьд шинэ нөхцөлд исламын шашин дэлгэрсний давуу болон сул тал нь юу вэ гэдэг нь анхаарал татаж байгаа юм. Сүүлийн 20-30 жилд исламын шашин улс төрийн шинжийг олж, исламын радикализм нь томоохон террорист халдлага үйлдэж, исламын янз бүрийн урсгал дэлгэрч, олон шинэ ойлголт бий болгож байгаа нь байдлыг төвөгтэй болгожээ. Нэгдүгээрт, исламын шашин бол казахын ард түмний үнэт зүйлийн хамгийн чухал тулгуур нь юм. Уг шашны нөлөөгөөр казахууд олон зуун жилийн турш угсаатныхаа нэгдлийг хангаж ирсэн байна. Ислам - шашин төдийгүй соёл юм. Монгол Улсад исламын шашин сэргээн дэлгэрснээр казахуудын угсаатны нэгдэл батжиж, хэл, соёл, заншил нь сэргээн мандахад чухал нөлөө үзүүлж байна. Мөн түүнчлэн өөрийн орондоо исламын шашныг шашныхаа дэгийн дагуу хөгжүүлэхийг гол болгон хүн төрөлхтний үнэт зүйлсийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа нь Монголын мусульманчуудын шашны хүрээнд хийж байгаа үйл ажиллагаанаас харагдаж байна.

Нөгөө талаар исламын шашинг эзэмшсэнээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны дэвшилд тэр хүрдэггүйг баримтууд нотолж байна. Тухайлбал, дэлхийн мусульманчуудын тэн хагас нь бичиг

үсэггүй, шинжлэх ухаан техникийн потенциал ихээхэн сул байгаа ажээ. Улсуудын шинжлэх ухаан техникийн хөгжлийг тодорхойлоход нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо чухал үзүүлэлт болдог. Тэгвэл 2005 онд исламын 57 улсын 1,5 тэрбум хүн нийтдээ 45425 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн бол АНУ-ын Нью-Йорк муж (19 сая хүнтэй) -52560 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна. Hi-Tech-ийн патентын хувьд 1997-2005 оны хооронд шинээр патент авахаар дэлхий даяар 986606 өргөдөл гаргасан бол түүний 5146 буюу 0,5% исламын орнуудынх юм. Патентын хувьд дөмөг нь Турк, Казахстан юм. 1901 оноос Нобелийн шагнал олгож эхлэх үеэс энхтайван, уран зохиолыг оролцуулахгүйгээр хатуу шинжлэх ухааны салбарт гэхэд физикийн 183 хүнээс нэг, химийн 195 хүнээс нэг, анагаах ухааны 192 хүнээс нэг хүн тодорчээ. Олимпын хувьд өвөл, зуны олимпид 5283 алтан медаль олгогдсоноос исламын орнуудыг авсан медаль 102 (0,01%), Турк 37 алттай 30-р байранд, Иран 11 алтаар 46, Казахстан 10 алтаар 48-р байранд байгаа бол АНУ 1009 медалиар нэгдүгээрт байгаа билээ. Казахстан 7 алт, нийт 13 медаль авч Лондонгийн олимпод 204 улсын дотор 12-р байранд орж, исламын орнуудыг тэргүүлсэн билээ.

Монгол Улсын мусульманчууд нь уугуул хэл соёлоо хадгалж, бүрэн бичиг үсэгтэй өөрийн үндэсний сэхээтэн бүрэлдсэн ба энэнд 24 шинжлэх ухааны доктор (Sc.D), 61 доктор (Ph.D) болон профессорууд, ардын багш, ардын эмч нарыг багтаасан зохих эрдэм шинжилгээний потенциалтай, Монгол улсын хөдөлмөрийн баатар 28, Монгол Улсын гавьяат зүтгэлтэн 70, Монгол Улсын төрийн соёрхлыг 8 казах хүн авсан ба казахуудын ихэнх нь 2-4 хэлний мэдлэгтэй билээ. Нэг нейрохург казах эрдэмтэн 12000 хүнд тархины нарийн мэс засал хийсэн жишээ бас байна. Гэхдээ сүүлийн 20-иод жилд эдийн засгийн ядуурал, ажилгүйдэл, нүүдэл суудал зэрэг нь тэдний имиджийг өөрчилж оюуны хоцрол руу түлхсэн юм. Одоо тэдний өмнө алдсан бүхнээ нэхэн олох, дэлхийн хөгжлийн ерөнхий хандлагын хүрээнд байж, дэвшилтэт технологи, инновацийг эзэмшин байж хязгааргүй технологийн инновацид суурилан гарах шинэ эдийн засаг, технологийн орчин үед зохицсон амьдрлын замд байх ёстой билээ. Өнөөгийн орчин үед болж буй хямралууд нь технологийн шинэ хувьсгалын өмнөх даваа юм. Хямрал, зогсонгүй байдал эцэс болж шинэ ухаалаг эдийн засаг, шинэ технологийн эрин үе ойртож байгаа юм. Иймд, Монголын мусульманчууд эх орныхоо хөгжил дэвшлийн идэвхтэй хүчин байж,

ардын исламын уламжлалыг хадгалан, орчин үеийн исламын үнэт зүйлийг эзэмшин, Казахстаны хөгжлийн хүрээнд байж хэмээн дараагийн зуунуудын өрсөлдөөнд тэсэн гарч чадах билээ.

**ЭШЛЭЛ. ЗҮҮЛТ:**

1. The Persian Inscription of 742 A.H. from Qaraqorum. In the Journal of the Inner Asian Languages. XXII, 2007. pp.119-156
2. En.wikipedia.org./wiki/Islam in Mongolia
3. www.toologo2010mn./doc/Mainresuelts\_20110615\_to EZBH -for print.pdf.p
4. Egemen Kazakhstan. 18.06.2010

**Abstract**

Mongolia is one of the countries where Islam has spread. Studying the history of spread of Islam and present situation in Mongolia which is a part of Central Asian civilization became an important issue. Islam and Muslims in Mongolia overcame difficult and harsh fate in various phases of history and reached the period of today's democracy and globalisaztion and favourable conditions of spread of Islam in Mongolia.

**Keywords:** Mongolia, Islam, Central Asia, Kazakh